

# Олон улсын Театрын Институт

## Гүйцэтгэн тоглох урлагийн дэлхийн байгууллага



### Дэлхийн Театрын Өдөр 2023 – 3 дугаар сарын 27

**Самиха Аёобын намтар, Египет**  
Египетийн жүжигчин

Монгол (Орчуулга)

---

**Самиха АЁОБ**  
Египетийн жүжигчин

Каир хотын Шубра дүүрэгт төрсөн жүжигчин. Драмын урлагийн дээд сургуулийг жүжгийн зохиолч Заки Тулайматын удирдлага дор суралцан 1953 онд төгссөн. Тэрээр уран бүтээлийн гараагаа эхэлснээс хойш 170 гаруй жүжигт тоглосон ба *Raba'a Al-Adawiya*, *Sekkat Al-Salamah*, *Blood on the Curtains of the Kaaba*, *Agha Memnon*, *The Caucasian Chalk Circle* зэргийг дурдаж болно. Уран бүтээлийнх нь дийлэнхийг тайзын бүтээл эзэлдэг боловч цөөнгүй тооны кино болон телевизийн бүтээлүүдэд оролцон хувь нэмрээ оруулсан байна. Кино дэлгэцийн *The Land of Hypocrisy*, *The Dawn of Islam*, *With Happiness*, *Among the Ruins* зэрэг бүтээлүүдээрээ алдартай бөгөөд телевизийн салбарт өөрийн гэсэн өнгө төрхөөр ялгарч чадсан ба үүнд *Stray Light*, *Time for Roses*, *Amira in Abdeen*, *Al-Masrawiya* зэрэг бүтээлүүдийг дурдаж болно. Уран бүтээлүүдээрээ үнэлэгдэн олон ерөнхийлөгчөөс, тухайлбал Абдел Нассер болон Анвар Садат, Сири улсын ерөнхийлөгч Хафез ал-Ассад, францын ерөнхийлөгч Жискард д'Эстэйн нараас өндөр дээд шагнал хүртсэн юм.